



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014. 07. 14 № 1/1154
танай _____-ны № _____-т

**АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ**

Чиглэл хүргүүлэх тухай

"Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-д зааснаар тэжээгчийг нас барах үед түүний асрамжинд байсан, хуульд заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тухайлбал, эмэгтэй нь **55 нас, эрэгтэй нь 60 нас хүрсэн эхнэр, нөхөр** тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Гэтэл хуулийн энэ заалтыг зөрчиж тэжээгчийн нөхөр (эхнэр) нь нас барахад 60 (55) настай хүрээгүй байсан нөхөр (эхнэр) нь нөхөр (эхнэр)-өө нас барснаас хойш тодорхой хугацааны дараа 60 (55) нас хүрээд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн хувьд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгож байна.

1. "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг зөрчиж олгосон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч буй бүх иргэдийн тэтгэврийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоох (үүнээс өмнө зогсоосон бол тухайн хугацаанаас эхлэн дор дурдсан арга хэмжээг авах).

2. Тэжээгчээ алдсаны тэтгэврээ зогсоолгосон иргэдийн хувьд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

а/ "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-д заасан болзол, нөхцөлийг хангаж буй иргэдэд холбогдох (өндөр насны болон тахир дутуугийн) тэтгэврийг хуулийн дагуу тогтоон олгох;

б/ "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-д заасан болзол, нөхцөлийг хангаагүй (эсвэл тодорхой хугацааны дараа хангах хүртэл) иргэдийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгохоор шилжүүлэх;

в/ "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль"-ийн дагуу 1990-2000 оны хооронд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах боломжтой иргэдийг уг хууль, холбогдох журам, аргачлал, чиглэлийн дагуу бүртгэж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх;

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ эдгээр тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид зөв зүйтэй тайлбарлан ойлгуулах, цаашид "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан заалтыг чанд мөрдөж, зөвхөн тэжээгчийн нас барсан өдөр нөхөр (эхнэр) нь 60 (55) насанд хүрсэн тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоон олгож ажиллахыг анхааруулъя.

ДАРГА

Ц.УРТНАСАН